

**"ИДЭЭ УНДААНЫ ЖИНХЭНЭ ТОВЧ"-Д БУЙ ТҮРЭГ, АРАБ, ПЕРС ГАРАЛТАЙ ИДЭЭ,
УНДААНЫ НЭРИЙН ТАЙЛБАР**

Очирхүү Самбуу¹, Шарав Буяндэлгэр², Дашжамц Шагдарсүрэн²,
Баттогтох Гэрэлмаа¹, Баасанжав Халиунаа¹, Шарав Болд^{1,2*}

Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим

¹Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

²"Ач" Анагаах Ухааны Их Сургууль

*Цахим хаяг: shrvbold@gmail.com

**EXPLANATION OF THE NAMES OF SOME TURKISH, ARABIC AND PERSIAN DIET IN
"FUNDAMENTAL PRINCIPLES OF FOOD AND DRINK"**

Sambuу Ochirkhuu¹, Buyandelger Sharav², Shagdarsuren Dashjamts²,
Gerelmaa Battogtokh¹, Khaliunaa Baasanjav¹, Bold Sharav^{1,2*}

Department of Traditional Medicine

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²"Ach" Medical University

*Email: shrvbold@gmail.com

Abstract

Introduction: This time, we will clarify the terms used to express the traditional medical knowledge of Turks, Arabs, Persians, Khotons, or Uyghurs that have not been deeply explored by researchers in the book "Fundamental Principles of Food and Drink." In addition, we propose to lay the foundation for studying the level of ancient medical relations between the ancient Mongols and Islamic countries and to create a new direction of research. Therefore, it is important to conduct a detailed study based on the sample of words related to food, drink, and herbal medicine of Islamic countries such as Turks, Arabs, Persians, and Uyghurs in the book "Fundamental Principles of Food and Drink" besides from Chinese medicine.

The aim of the research: To explain the names of food and drink of Turkic, Arabic, and Khoton (Uyghur) origin in the "Fundamental Principles of Food and Drink" of 1330 AD.

Research results: Paul D. Buell and Eugene N. Anderson (2010), who translated the book "Fundamental Principles of Food and Drink" into English titled "A Soup for the Qan" with an explanation, have extensively and seriously considered how the book relates to the Islamic world. These researchers also say that "the diet, medicinal plants, and grains of the Islamic world reflect a common Middle Eastern (Iranian-Arab) culture rather than the specifics of the Turkic peoples. However, since Turkic elements are dominant in other parts of Islamic culture, there is no doubt that the Turkic forms of some Arabic and Iranian words are often found in "Fundamental Principles of Food and Drink." Therefore, we have selected some words from Paul D. Buell and Eugene N. Anderson's book "A Soup for the Qan" and considered them to be Turkic, Persian, and Arabic words. In fact, there are 36 Turkic origin words, 4 Persian origin words, and 5 Arabic origin words. However, if we look closely, we find that there are quite a few Mongolized Turkic words and Turkized Mongolian words. Conclusion: In the book "A Soup for the Qan" translated from Chinese with commentary into English by Paul D. Buell and Eugene N. Anderson, words of Turkic, Persian, and Arabic origin, namely 36 Turkic words, 4 Persian words, and 5 Arabic words, were selected and noted. Our research revealed that 11 of these 45 chosen words were Mongolian or Mongolian words of Turkic origin after thorough analysis. This result is in line with Bold Sharav's 2022 book, which explained and noted that there were 23 Mongolian words in "Fundamental Principles of Food and Drink," and it became clear that there were a total of 34 Mongolian or Mongolian words of Turkic origin words.

Keywords: Mongolian medicine, Islamic culture, herbal medicine, Mongolian words, Turks and Arab words

Үндэслэл

Монголчуудын идээ ундааны хэрэглээний талаар товч төдий дурдсан судар ном, сурвалж

бичгүүдээс үзэхэд 14 дүгээр зууныг хүртэл Монголын тэжээхүй ухааныг судлах асуудал цогц байдлаар тавигдаж байгаагүй, бас тусгайлсан

дорвитой бүтээл гараагүй байжээ. Харин 14 дүгээр зууны 30-аад оны үед Юань улсын хааны ордны дотоод асуудал эрхэлсэн сайд, зоогийн эмч Хүсэхүй нь Юань улсын хаадын хэрэглэж байсан идээ, ундааны зохистой хэрэглээг өөрийн туршлагатай уялдуулан “Идээ ундааны жинхэнэ товч” бүтээлээ туурвиж үлдээсэн байна. “Идээ ундааны жинхэнэ товч” зохиол гурван ботиор бичигдсэн, оршил хэсэгтээ гурван эзэн хааны талаар дурдсан, нийт 184 зураг чимэглэлтэй бүтээл юм¹. Уг зохиолд буй хоёр оршил, зохиолын агуулга, Хөхлуу гуайн аман ярианд үндэслэн Хүсэхүйн талаар бүтээлдээ дурдсан судлаач Б.Эрхэмбат (1987), Ш.Болд (1999) нар: Хүсэхүй нь Монгол хүн байсан болох таамаглал дэвшүүлж, БНХАУ-ын Бээжин хотод буй Хятад эмнэлгийн их сургуулийн музейд байгаа Хүсэхүйн бүтээлийн танилцуулгад түүнийг Монгол үндэстэн байсныг тодорхой тэмдэглэж баримтаар баталгаажуулжээ².

Хөхлуу гүүшийн орчуулсан “Идээ ундааны жинхэнэ товч” зохиолын ачаар энэ номыг судлах, кирилл үсгээр буулгах боломж бүрдэж анхны хөрвүүлгийг Г.Пагма хийж Эрдэнэт хотод 1990-ээд оны сүүлээр хэвлүүлсэн³. Дараа нь Ш.Болд, М.Амбага нар 2002 онд бичсэн “History and Fundamentals of Mongolian Traditional Medicine” номондоо англи хэлээр дурдсаны зэрэгцээ Ш.Болд 2007 онд англи хэлээр бичсэн “Insight into the Secrets of a Mongolian Healthy Lifestyle” бүтээлдээ “Идээ ундааны жинхэнэ товч” номын эрүүл аж төрөхөд цээрлэх зүйл, жирэмсэн эмэгтэйн идээ, ундааны цээрлэх зүйл, төрсөн эхийн цээрлэх зүйл, архи дарс уух үед цээрлэх зүйлийг англи хэлээр орчуулан хэвлүүлжээ.

Судалгааны хувьд ШУТИС-ийн судлаач Д.Оюун-Эрдэнэ⁶ 2008 онд энэхүү бүтээлийг судлан магистрын зэрэг хамгаалсан байна. Түүнчлэн Т.Алимаа, С.Сэдэддулам нар “Идээ ундааны жинхэнэ товч” номыг монгол бичгээс хөрвүүлэн 2012 онд хэвлүүлжээ⁷. БНХАУ-ын ӨМӨЗО-ны судлаач О.Урнаа “Идээ ундааны жинхэнэ товч” номыг судалж 2020 онд АУ-ны докторын⁸ зэргийг хамгаалсан байна. Хамгийн сүүлд Ш.Болдын хуучин монгол орчуулга, Мин

улсын хятад эх, англи тайлбартай орчуулгуудад тулгуурлан энэхүү номыг шинээр орчуулахдаа номын гарал үүсэл, нэрийн учир, зохиогч, хуучин өмнөтгөл, зарим үгийн утгын тайлбарыг өргөн хүрээнд хийж англи хураангуйн хамт хэвлүүлжээ. Хүсэхүйн «Идээ ундааны жинхэнэ товч»-д айраг, эсэг, цэгээний талаар хятад үсгээр монгол дуудлагаар бичиж үлдээсэн нь нэн сонирхолтой бөгөөд аргагүй л нүүдэлчдийн идээ ундааны уламжлалт төрлийг багтаасан сонгодог бүтээл гэдэг нь нотлогдож байна.

Гэхдээ энэ удаа бид судлаачдын гүнзгий хөндөөгүй Түрэг, Араб, Хотон буюу Уйгарын уламжлалт анагаах ухааны мэдлэгүүд ямар нэр томьёогоор илэрхийлэгдэж хэрхэн тусгалаа олсныг тодруулах, Монголчууд болон исламын шашинт орнуудын анагаах ухааны эртний харилцаа ямар түвшинд байсныг судлах эхлэлийг тавих, судалгааны шинэ чиглэлийг бий болгох асуудлыг дэвшүүлэн тавьж байна.

Тиймээс бид “Идээ ундааны жинхэнэ товч” номноос хятадаас гадна түрэг, араб, перс уйгар зэрэг исламын шашинтай улс түмний хоол унд, эмтэй холбоотой үгийн түүвэрт үндэслэн нарийвчлан судалгаа хийж монгол гаралтай, эсвэл түрэг гаралтай үгийн хэрэглээг товч тодорхойлохын тулд энэхүү судалгааг хийв.

Судалгааны ажлын зорилго

Хүсэхүйн 1330 онд “Идээ ундааны жинхэнэ товч”-д байгаа түрэг, араб, хотон (уйгар) гаралтай идээ, ундааны нэрийн тайлбар хийх.

Судалгааны арга

- Эх бичиг судлалын арга

Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилго, зорилтууддаа нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн судалж, улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд шинэлэг санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзэв. Энэ аргаар Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч” номын нэр, газар орон, агуулга, эх хэрэглэгдэхүүн, галиг, тайлбар, харьцуулалт зэргийг нэгэн дор хамтатган судлав.

- Харьцуулалтын арга

“Идээ, ундааны жинхэнэ товч” номонд байгаа араб, перс, түрэг, уйгар идээ, ундаа, эмийн нэрийг хэл шинжлэлийн болон уламжлалт анагаах ухааны нэр томъёоноос түүвэрлэн хооронд нь харьцуулан гарал үүсэл, ялгаатай, төсөөтэй талуудыг тогтоох.

Судалгааны үр дүн

“Идээ, ундааны жинхэнэ товч” номын доторх зарим идээ, ундаа, ургамал, амьтны гаралтай эмийн түүхий эдийн нэр араб, түрэг, хотон (уйгар)-гоос гаралтай байна. Тиймээс энэ номыг бичсэн Хүсэхүй эмч монголоос гадна араб, перс, түрэг, хотон (уйгар) зэрэг исламын шашин шүтдэг орны ард түмний өдөр тутмын хоол ундны хэрэглээнээс эмчилгээний болон шимжүүлэх үйлдэл сайтай идээ, ундааг олонтоо оруулан сонгон авчээ.

“Идээ, ундааны жинхэнэ товч” номыг тайлбартайгаар англи хэлээр орчуулсан Paul D. Buell and Eugene N. Anderson (2010) нар исламын ертөнцтэй уг ном хэрхэн холбогдож буйг өргөн хүрээтэй нухацтай авч үзсэн байдаг. Тэд, “Идээ, ундааны жинхэнэ товч” номонд Исламын орнуудын амтлагч, түүхий болон боловсруулсан хоол хүнс, эм бэлдмэлийн аргыг дагаж мөрдлөг болгодог. Олонх нь хоол, хүнс, эмийн зүйлс нь анх удаа уг сурвалжид гарч ирсэн бол зарим нь уг номыг бичигдэхээс өмнө Хятадад удаан хугацаагаар ашиглагдаж байсан бөгөөд зарим тохиолдолд Хан улсын үед ч байсан хэмээн бичжээ⁹.

“Идээ, ундааны жинхэнэ товч” номонд байгаа хоол, ундаанд хэрэглэдэг халуун ногоо, жимс, амтлагчууд хоолны хэрэглээний хувьд уламжлалт зүйл учраас шинэ гэж хэлэх боломж муу юм. Харин шинэ зүйл нь халуун ногоо, жимс, амтлагч ногоо, зарим эмийн ургамлыг амьтны гаралтай улаан идээтэй нийцүүлэн хослуулж эмийн журмаар хэрэглэж болохыг тодорхойлж өгсөн нь үнэхээр шинэ мэдлэг болж байна.

Paul D. Buell and Eugene N. Anderson нар бүтээлдээ “Исламын ертөнцийн хоол хүнс, эмийн ургамал, тариа нь түрэг үндэстний соёлын онцлогоос илүү нийтлэг Ойрх Дорнод (Иран-Араб)ыг тусгадаг. Гэхдээ Исламын

соёлын бусад хэсэгт түрэг соёлын элементүүд давамгайлж байгаа тул зарим араб, иран үгсийн түрэг хэлбэрийг авч үзвэл “Hu Sihui’s Yinshan Zhengyao” (Идээ, ундааны жинхэнэ товч) номонд ихэвчлэн тохиолддог гэдэгт эргэлзэх зүйл алга” гэжээ¹⁰.

Тэгээд цааш нь жорын ангиллаас харахад “Идээ, ундааны жинхэнэ товч” номын жоруудын гуравны нэг, магадгүй илүү олон нь Турк-Исламын ертөнцөөс шууд дамжуулагдсан байдаг” гэсэн нь анхаарал татаж байна.

Тиймээс бид Paul D. Buell and Eugene N. Anderson нарын бүтээлээс тэдний түүсэн түрэг, араб зэрэг нийт 45 үг, хэллэгийг дахин нягталж, монгол үгийн утга, дуудлагатай харьцуулан дахин нягталж үзлээ. Түрэг хэлний хамгийн эртний мэдэгдэж буй хэлбэр болох эртний түрэг хэл нь одоогийн Монгол Улс, Казахстан, БНХАУ-ын зарим хэсгийг хамарсан Туркестаны сав газарт НТ 6 дугаар зуунд үүссэн гэж үздэг.

Алтайн хэлний язгуурын хэлүүдээс хамгийн ойрхон ижил төрөл хэлүүдийн сонгодог жишээнд Монгол, Түрэг хэл орно. Тиймээс энэ хоёр хэлний үгсийн санд буй зарим үгнүүд Түрэг хэлнээс Монгол, Монгол хэлнээс Түрэг хэлэнд орсон үгнүүд юм.

Монголжсон араб, түрэг, хотон (уйгар) гаралтай үгийн утгыг тайлбарлахуй

Paul D. Buell and Eugene N. Anderson нар “Идээ, ундааны жинхэнэ товч” номоос дараах үгийг түүж Түрэг, Перс, Араб хэлний үгс хэмээн үзжээ. Чухамдаа: түрэг үг 36, Перс 4, Араб 5 үг байна. Гэхдээ нарийн үзвэл монголжсон түрэг үг, түрэгжсэн монгол үг цөөнгүй байна. Эхлээд бид Paul D. Buell and Eugene N. Anderson нарын номноос дараах түүврийг хийв¹¹. Үүнд:

А. Халуун ногоо, түүхий хүнс

1. angwa (Pr.), asafoetida
2. anjudan (Ar. from Pr. anguzhad), “asafoetida root”
3. badam (Pr.) “almond”
4. chugundur (Pr.) “sugar beet”
5. ka’fur (Ar.) camphor
6. hulba [t] (Ar.) “fenugreek”
7. kasni (Pr.) “asafoetida”

8. mäska (Tu.) “refined liquid butter”
9. qatiq (Tu.) “dried sour milk”
10. qima (Tu.) “chopped meat (as noodle stuffing)”
11. shajhimur (Tu. from Ar. shaljam) “rape turnip”
12. suqsur (Tu. from Mo.?) “common pintail,” *Anas acuta*
13. surqyl (Tu.), [“grayish, whitish one”] “immature mute swan”
14. süttigen, (No. Tu.: “having a basis in milk”), here “Mongolian tea”
15. za’faran (Ar.) “saffron”
16. zhira (Pr.) “cumin”

В. Идээ, ундааны нэр

1. Achchiq (Tu.), “Sour”
2. arajhi (Tu. from Ar.), “distilled liquor”
3. boza (Tu.) “beer,” “brandy?”
4. chöp (Tu.) “noodles”
5. Chöppün [or chöp bün] (Tu.) “Noodle Soup”
6. chuqmin (Tu.) “bread steamed in a pot”
7. Chizig (Tu.) “dish made from sheep’s tail fat and flour”
8. Ishkänä (Tu.) “broth into which bread is crumbled, food taken with bread”
9. jis kebabi (Tu. from Pr.) “kebabs,” piece of meat roasted on a skewer
10. Jüzmä (Tu.) a flat pancake noodle filled with onions and meat
11. manta (Tu. from mamata?) “stuffed bread, breaded meat”
12. Näwälä (Pr.) “meat, food”
13. Päräk (Tu.) “dumpling filled with fat and meat, e.g. börek”
14. Qazi (Tu.) here: “a sheep intestine stuffed with spices” rather than the expected horse stomach
15. quruq qima (Tu.) chopped, parched meat
16. Shilön (Tu. from Mongolian) “soup”
17. Shoyla Toyym (Tu.), “Porridge Abundance”
18. salma (Tu.) “small thin soup noodles”
19. Samsa (Tu. from Pr.), samusa
20. Sharba[t] (Ar.) “syrup”
21. sürmä (Tu. from Ar. sharba[t]?) “liquor,” in the ИУЖТ: “brandy”
22. tngri (Tu.) here: a variety of Qaraqojha Wine
23. Tutum Ash (Tu.) “noodles”

24. [Tangut] Um Ash (Tu.) lamb-filled soup noodles made of flour
25. Umach (Tu.) “a hand-twisted noodle”
26. Yubqa (Tu.) “pot cooked bread stuffed with meat and onions”

С. Төрөл бүрийн нэр томъёо

1. Qaraqojha (Tu.) place name
2. qashiq (Tu.), “spoon”
3. sashuq (Tu.) “small coin”

Бид дээрх түүврээс монгол гаралтай эсвэл монголжсон түрэг гаралтай 11 үгийг түүвэрлэн нарийвчлан авч үзэн дараах байдлаар тайлбар хийлээ.

1. suqsur (Tu. from Mo.?) “common pintail,” *Anas acuta* – **сугсур** - эгэл **сойр** шувуу эсвэл **шовтгор** алаг нугас.

2. süttigen, (No. Tu.: “having a basis in milk”), here “Mongolian tea” – **сүттиген** - сүүнд үндэслэсэн цай уух. Монголоор **сүүтэй цай**

3. arajhi (Tu. from Ar.), “distilled liquor” – агажхи – нэрмэл архи. **Агажхи** гэдэг эртний түрэг үг монголоор **архи** гэсэн үг болж үгсийн санд орсон байна.

4. boza (Tu.) “beer,” “brandy?” – **боза** – шар айраг, шатам архины түрэг нэр Монгол хэлний үгсийн санд гурав нэрсэн хатуу архины нэр **борз** болжээ.

5. Qazi (Tu.) here: “a sheep intestine stuffed with spices” – **кази** – амтлагч хийсэн хонины гэдэс - **каз** /казакаар-казы/ бол Монголын казахын ард түмний хамгийн хүндэтгэлтэй хоолны нэр болсон.

6. Shilön (Tu. from Mongolian) “soup” - **шилөн-шөл** гэсэн монгол үг.

7. salma (Tu.) “small thin soup noodles” – **салма** – жижиг нарийн гурилтай шөл – өнөөгийн монголчуудын идэх дуртай **салбадай** шөлний нэр бололтой.

8. qashiq (Tu.), “spoon” – **гашиг** – сайн чанарын төмөр гэсэн монгол үг. Сайн чанарын төмрөөр хийсэн халбагыг турк хэлээр гашиг гэдэг байжээ.

9. Samsa (Tu. from Pr.), samusa – **самса** - гурвалжин хэлбэртэй махан хоол. Монголд энэ үг хамрын нүхний 2 хонхор, уруулыг холбосон гурвалжин хэсгийг хэлнэ. **Самсаа** шархирах гэвэл хүний хамрын нүхний хоёр хажуугийн

бяцхан хонхор, уруул хоорондын хэсэг орон татвалзан нулимс гоожихыг хэлдэг.

10. qima (Tu.) “chopped meat (as noodle stuffing)” – **гима** гэж мах хэрчсэн гурилтай хоол. Зарим нутагт **гийдаа** гэж хэлнэ. Ингэж нэрлэдэг турк хоол ч байдаг.

11. zhira (Pr.) “cumin” – **зира**- гоньд юм. Одоо ч Монголд гоньдыг **зираа** гэдэг.

Хэлцэмж

Судалгаанаас үзэхэд энэхүү 11 үгийг өнөөдөр ч монголчууд үг яриандаа ялангуяа утга зохиолын хэлэндээ хэрэглэсээр байна. Ер нь Paul D. Buell and Eugene N. Anderson нар “Идээ ундааны жинхэнэ товч” номыг Исламын ертөнцийн хоол хүнс, эмийн ургамал, тариа нь түрэг үндэстний соёлын онцлог, ялангуяа Ойрх Дорнод (Иран-Араб)-ыг тусгадаг хэмээн хэлбийлгэх, түүнийгээ нотлохыг ихэд оролдсон байдаг. Гэвч тэдний түүсэн 45 үгнээс гэхэд л 11 нь Монголжсон түрэг, эсвэл Түрэг гаралтай монгол үг гэдэг нь тодорхой байна. Бусад үгийг хэл шинжлэлийн нарийн мэргэжлийн судлаачид нарийн судалвал нэмээд ч бидний мэддэг үгнүүд хэд хэд гарах боломжтой юм.

Үүний зэрэгцээ Ш.Болд 2022 онд хэвлүүлсэн номондоо: судлаач Paul D. Buell and Eugene N. Anderson нар “A Soup for the Qan” бүтээлдээ “Хүсэхүйн «Идээ ундааны жинхэнэ товч»-д 23 монгол үг, хэллэг байх магадлалтай. Эдгээр үгүүдийг «Идээ ундааны жинхэнэ товч»-д байгаа гадаадын бусад үгүүдтэй нэгэн адил хятадаас галиглан сэргээж болно. Галиг нь ихэнхдээ буруу сонссон, буруу дамжуулсан, эсвэл эх үгээ өөрсдөө буруу ойлгосноос болдог. Авиа зүйн хувьд Хойд Хятадын аялгуунд гадаад үг ялангуяа Түрк, Монгол хэлний олон үгийг илэрхийлж чадахгүй байснаас ...” тухайн үгийг шууд дуудлагаар нь бичиж үлдээжээ¹²” хэмээсэн байна. Ш.Болд судлагааны явцад Paul D. Buell and Eugene N. Anderson нарын түүсэн 23 үгэн дээр 1 үг нэмж нийт 24 монгол гаралтай үгийг түүж, оноолт болон тайлбарыг шинэчилжээ¹³.

Гэхдээ бидний судалгаагаар “Идээ ундааны жинхэнэ товч” ном бол Араб, Түрэг гаралтай исламын шашинт ард түмний зохиол гэхээсээ

илүүтэй Хүсэхүй гэдэг монгол хүний хятад хэлээр бичсэн араб, түрэг, хотон (уйгар) гаралтай идээ, ундааг багтаасан буюу олон үндэстний хоол хүнсний анагаах үйлдлийг нэгтгэн бичсэн монгол зохиол хэмээн үзэж байна.

Дүгнэлт

Paul D. Buell and Eugene N. Anderson нарын хятад хэлнээс тайлбартайгаар англи хэлээр орчуулсан “Hu Sihui’s Yinshan Zhengyao” номонд буй түрэг, перс, араб гаралтай хэлний үгс тухайлбал, түрэг үг 36, перс 4, араб 5 үгийг түүж тэмдэглэжээ. Бидний хийсэн судалгаагаар эдгээр 45 түүвэр үгнээс 11 нь монголжсон түрэг, эсвэл түрэг гаралтай монгол үг гэдгийг тал талаас нь шинжилж нь тодруулав. Энэхүү үр дүн нь Ш.Болдын 2022 онд хэвлүүлсэн номондоо Хүсэхүйн «Идээ ундааны жинхэнэ товч»-д 23 монгол үг, хэллэг байгааг тайлбарлан тэмдэглэсэнтэй нийлээд 34 монгол үг байгаа нь тодорхой болов.

Ном зүй

1. Хүсэхүй. Идээ ундааны жинхэнэ товч. (Орчуулсан Ш.Болд). УБ, 2022, х.23
2. Хүсэхүй. Идээ ундааны жинхэнэ товч. (Орчуулсан Ш.Болд). УБ, 2022, х.26-27
3. Хүсэхүй. “Идээ ундааны жинхэнэ товч” (хөрвүүлсэн Г.Пагма, тайлбар хийж редакторласан Д.Дэмбэрэлдорж), Эрдэнэт хот (Хэвлэсэн оноо бичээгүй).
4. Bold Sh, Ambaga M. History and Fundamentals of Mongolian Traditional Medicine. UB, “Sod Press”, 2002, (in English), p.23
5. Bold Sh. Insight into the Secrets of a Mongolian Healthy Lifestyle. Ulaanbaatar, “Munkhiin useg” Printing House, 2007
6. Д.Оюун-Эрдэнэ. Хубилай цэцэн хааны “Идээ ундааны жинхэнэ товч” зохиолыг судлах асуудалд (XIV зуун). Эрдэм шинжилгээний ажлын удирдагч АУ-ны доктор Ш.Болд. Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ШУТИС, УБ, 2008
7. Т.Алимаа, С.Сэдэддулам. “Идээ ундааны жинхэнэ товч” (Редактор Н.Төмөрбаатар).

- УБ, “Мөнхийн үсэг”, 2012
8. Урнаа (Wu Ri Na). “Идээ ундааны жинхэнэ товч” бүтээлийн сурвалжийн хийгээд ургамлын нэршлийн оноолтын судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч АУ-ны доктор, профессор С.Сээсрэгдорж, БУ-ны доктор, дэд профессор Ж.Байгалмаа. АШУҮИС, УБ, 2020
 9. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Er As Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, pp.106
 10. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era As Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, pp.121-122
 11. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era As Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, pp.106-113
 12. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, p.90-95
 13. Хүсэхүй. Идээ ундааны жинхэнэ товч. (Орчуулсан Ш.Болд). УБ, 2022, х.34